

2025 / 3 / 17

№ 25/04

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76.1.17 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн эчнээ санал хураалтын дүнд үндэслэн

### ТОГТООХ НЬ:

1. Компанийн биет болон биет бус хөрөнгөөс долоон (7) тэрбум хүртэлх төгрөгийн хөрөнгийг Ард кредит ББСБ ХК-д худалдахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Худалдах хөрөнгийн жагсаалт гаргах, хөрөнгийн үнэлгээг балансын үнээс бууруулахгүй байхаар тооцох, холбогдох гэрээ хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)-д **ОЛГОСУГАЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудит эрхэлсэн захирал (М.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг **БОЛГОСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025 / 3 / 17

№ 25 / 05

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, 76.1.6 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (“Компани”)–ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТҮЗ” гэх)–ийн эчнээ санал хураалтын шийдвэрийн дагуу

### ТОГТООХ НЬ:

1. Компанийн болон нэгдлийн оролцогч компаниудын эзэмшиж буй Ард Даатгал ХК–ийн нийт гаргасан хувьцааны 50 хувьтай тэнцэх хувьцааны нийт үнэлгээг 20,000,000,000 (хорин тэрбум) байхаар **ТОГТООСУГАЙ;**
2. Тогтоолын нэг дэх хэсэгт заасан хувьцааг Компанийн холбогдох этгээдэд бүхэлд нь болон хэсэгчлэн худалдах хэлцэл хийхийг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ;**
3. Хувьцааны арилжааг гүйцэтгэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон ханшаас багагүй үнийн дүнгээр гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)–д үүрэг **БОЛГОСУГАЙ;**
4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, Компанийг төлөөлөн холбогдох гэрээ хэлцлийг байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)–д **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025 / 3 / 17

№ 25/06

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (“Компани”)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн

### ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувь эзэмшил бүхий Өндөрхаан ХК-д 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн урт хугацаатай санхүүжилт олгохыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ**;
2. Өндөрхаан ХК-д олгох санхүүжилтийн эргэн төлөлтийн хуваарь, нөхцөл, журмыг Хавсралт 1-ээр **БАТАЛСУГАЙ**;
3. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан санхүүжилтийг холбогдох гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах нөхцөлтэй болохыг **ДУРДСУГАЙ**;
4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, Компанийг төлөөлөн холбогдох гэрээ хэлцлийг байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)-д **ДААЛГАСУГАЙ**.

ДАРГА



Ц.ГАНХУЯГ

2025 / 3 / 17

№ 25/07

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76.1.17 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн эчнээ санал хураалтын дүнд үндэслэн

### ТОГТООХ НЬ:

1. Компанийн Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан 3,200,000 (гурван сая хоёр зуун мянган) ам.долларын зээлийг 2025 оны I улиралд багтаан Ард кредит ББСБ ХК-д **ШИЛЖҮҮЛСҮГЭЙ**.
2. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан асуудлаар хэлцэх хийх, хэлцэл хийхэд шаардлагатай арга хэмжээг авах, хөрөнгө шилжүүлэх, хөрөнгийн даатгалыг хариуцуулах зэрэг холбогдох гэрээ хэлцэлд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)-д **ОЛГОСУГАЙ**.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудит эрхэлсэн захирал (М.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг **БОЛГОСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ